

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Ерөнхий шаардлага

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, Хотонт үржлийн хэсгийн хонийг цаашид тоо толгойг нь өсгөх, үүлдэрлэг байдал, ашиг, шимийг нэмэгдүүлэх, цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор Хотонт үржлийн хэсгийн 330 толгой хонийг түрээсээр ашиглаж, сум орон нутгийн малчид, аж ахуй нэгжүүдийг стандартад тэнцсэн үржлийн хээлтэгч малаар тогтмол хангах үйлчилгээ үзүүлэх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахад дараах шаардлагыг баримтална.

1.1 Хотонт үржлийн хэсгийн 330 толгой хонийг түрээсээр ашиглаж, сум орон нутгийн малчид, аж ахуйн нэгжүүдийг стандартад тэнцсэн үржлийн хээлтэгч малаар тогтмол хангах үйлчилгээ үзүүлэх, шаардлага хангасан, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг сонгож, түрээсээр ашиглах гэрээ байгуулна.

1.2 Сонгон шалгаруулалт хийх ажлын хэсгийн гишүүн нь санал, хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжийг нэгжийг сонгож хувийн харьцаа тогтоох, бизнесийн нууцыг бусдад мэдээлэх, буруу үнэлгээ хийх, бусдад давуу байдал бий болгохыг хориглоно.

Хоёр. Аж ахуйн нэгжид тавигдах ерөнхий шалгуур

Хуульд заасны дагуу бүртгэлтэй, тогтмол мал үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байхаас гадна дор дурдсан шалгуурыг хангасан төсөл, санал ирүүлсэн байна.

Үүнд:

2.1. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны товч танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл

2.2. Байршил албан ёсны хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

2.3. Цөм сүргийн малыг өсгөн үржүүлэх эдийн засгийн тооцоо, дүгнэлт, бүхий сүргийн эргэлт бизнес төлөвлөгөө

2.4. Аж ахуйн нэгжийн бүтэц, орон тоо гишүүдийн мэргэжил, мэргэшлийн ур чадварын мэдээлэл, ажилчдыг томилсон тушаал, нийгмийн даатгалын лавлагаа, /мэргэжлийн боловсон хүчиний диплом мэргэшлийн үнэмлэх/

2.5. Цөм сүргийн малыг өсгөн үржүүлэхэд зайлшгүй шаардлагатай тэжээлийн хангамж түүнийг хэрхэн шийдвэрлэх талаарх мэдээлэл

2.6. Малын өвөлжөө, хаваржааны байр саравчийн талаарх мэдээлэл /зургаар баталгаажуулсан/

2.7. Малын өвөлжөө, хаваржааны байр саравчны талаарх мэдээлэл

2.8. Үржлийн багаж, хэрэгслийн жагсаалт /зургаар баталгаажуулсан/

2.9. Харилцагч банкны тодорхойлолт, зээлийн мэдээлэл

2.10. Мэргэжлийн мал зүйчтэй эсэх.

Гурав. Сонгон шалгаруулах

3.1. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг аж ахуйн нэгжүүдэд хүргэж, ажлын 7 хоногт багтаан материалыг хүлээн авна.

3.2. Ажлын хэсэг хүсэлт гаргасан аж ахуйн нэгжийн материалтай танилцаж, үнэлгээ өгч, хэлэлцэн, шаардлага хангасан аж ахуйн нэгжийг сонгоно.

3.3. Сонгогдсон Мал үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй Архангай аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн өмчийн газар хооронд гэрээ байгуулна.